



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 4/223

Мандалговь

“Газар усны нэр тодруулах ажил”  
(Багц-1 Сайнцагаан, Луус сум) зөвлөх үйлчилгээний  
ажил хүлээлцэх комисс томилох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 33 дугаар зүйлийн 33.5, Сангийн сайдын 2021 оны 160 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, тайлагнах журам”-ын 4.3.4 дугаар заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн “Газар усны нэр тодруулах ажил”-ын Багц-1 болох Сайнцагаан, Луус суманд зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Э.Чагнаадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Ш.Наран-Очир (“Вектор мэл” ХХК-ний захирал)

Гишүүд: Ж.Уянга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)  
Ж.Элбэгзаяа (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Геодези зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Т.Уранбайгаль (Архивын тасгийн дарга)

2. “Газар усны нэр тодруулах ажил”-ын Багц-1 болох Сайнцагаан, Луус суманд зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Э.Чагнаадорж)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Л.БАЯРСАЙХАН

486211092